



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

**ХУТАГ-ӨНДӨР СУМЫН "ИЛЧИТ-
ХУТАГ" ОНӨААНҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.ШИНЭБАЯР ТАНАА**

2021.03.15 № 116
Танай _____-ны № _____ т

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААНҮГ 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийхээр байсан.

Илчит хутаг" ОНӨААНҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

- Санхүүгийн "Смарт баланс" программыг өөрчлөн "Лидер 03" программыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэсэнтэй холбоотойгоор тодруулга тайлангууд, СТАУС-руу тайлан хөрвөх давуу тал үүссэн ч санхүүгийн тайлангийн үр дүн 278625.1 мянган төгрөгөөр буурч (363961.4) мянган төгрөг болж нийт хөрөнгө 4062500.6 мянган төгрөг болсон байна. Буурах гол шалтгаан нь үндсэн хөрөнгийн элэгдлийг үнэн зөв тооцож тайланд тусгадаггүй, бараа материалын зарцуулалтын бүртгэл тодорхой бусаас Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, дотоод хяналт сул байгааг илэрхийлж байна.
- Авлагын үлдэгдэл 45374.7 мянган төгрөг болж 6824.4 мянган төгрөгөөр, өглөгийн үлдэгдэл 791.9 мянган төгрөг болж 8184.5 мянган төгрөгөөр тус тус үндэслэлгүй бууруулсан, тооцоо нийлсэн актаар авлага 4300.0, өглөг 34.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.1.бие даасан байх, 5.1.2.тасралтгүй байх, 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн, 5.1.4.үнэн зөв байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; 14.4.3.бүх өр төлбөр", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.
- Бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл 47922.7, эцсийн үлдэгдэл 75857.1 мянган төгрөгөөр тайлагнасан ч санхүүгийн программ өөрчилсний дараах дүн эхний үлдэгдэл 51487.8, эцсийн үлдэгдэл 16173.9 мянган төгрөг болсон байна. Няравын

006020242

тайлангаар 28359.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэл, 22865.8 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй, тооллогоор 9338.9 мянган төгрөгийн бараа материалтай нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн, УСНББОУС-12 мөрдөөгүй

- Санхүүгийн байдлын тайлангаар үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 4196485.7 мянган төгрөг, программ сольсны дараах дүн 4006271.6 мянган төгрөг, тооллогоор 4265534.1 мянган төгрөг буюу зөрүүтэй /журнал бичилт, ерөнхий дэвтэр, ҮХ-ийн тодруулгууд зөрсөн- ҮХ дансны үлдэгдэл тулгалтаас харах/ тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д заасныг зөрчсөн, УСНББОУС-17 мөрдөж ажиллаагүй байна.
- Тус аж ахуйн тооцоот орон нутгийн өмчит газрын Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 4351218.2 мянган төгрөг байсныг программ сольсноор 4062500.6 мянган төгрөг болж 288717.6 мянган төгрөгөөр өөрчлөгдсөн, тайлант оны санхүүгийн тайлангийн дансуудын үлдэгдлийн тулгалтаар ерөнхий журнал, ерөнхий дэвтэр, шалган балансуудын дүн зөрүүтэй, нийт дүнгээр журналын бичилт хийсэн, холбогдох дансанд ажил гүйлгээг тусгадаггүй, олон жил болсон өглөг, авлагын дүнг нотлох баримтгүйгээр хаасан, тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүй, Төсвийн тухай хуульд заасан цаглавар хугацаанд санхүүгийн тайланг ирүүлээгүй зэрэг нь НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, УСНББОУС 12, 17 зөрчсөн байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР